

САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг ХЗДХЯ-аас боловсруулсан “Сангийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;

¹ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2021 оны 08 дугаар сарын 20

² “25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон..”

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйл. Төрийн мэдээлэл сэтгүүл 2015 оны №25

³ www.legalinfo.mn. Сүүлийн нэвтрэлт 2021 оны 08 дугаар сарын 20

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

Хууль тогтоомжийн тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл 2015 оны №25

4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Практикт хэрэгжих боломж:

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, Иргэний хуулийн зохицуулалтад тулгуурлан ашгийн бус хуулийн этгээдийн төрөлд нийцүүлэн, иргэд санг хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулахыг хуульчлан, сан нь хувийн болон нийтийн сан гэсэн 2 төрөлтэй байхаар тодорхойлж, тэдэнд тавигдах шаардлагыг ялгаатай байхаар тусгаж, дотоод засаглал, үндсэн зорилго үйл ажиллагааг эрхэмлэн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарч шинэчилсэн байна. Түүнчлэн санд үзүүлэх татварын болон бусад хөнгөлөлтийн зохицуулалтыг тусгаж, сангийн явуулж болохгүй үйл ажиллагааны хориглолтыг зохицуулсан.

Мөн сангийн хариуцулагыг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа санд төрөөс хөнгөлөлт үзүүлэх боломжийг олгосон зохицуулалтыг тусгасан байна.

Иймд эдгээр шинэлэг зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

➤ Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

➤ **Харилцан уялдаа:**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Манай улсын хувьд 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулиар ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тогтоон, холбогдох харилцааг зохицуулж ирсэн.

Гэвч нийгмийн харилцааны өөрчлөлт, шинэчлэлээс хамаарч тухайн зохицуулалтыг нарийвчлах, улмаар хуулийн зохицуулалтыг сайжруулан шинэчлэн найруулах шаардлага тулгарсан.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд Монгол Улсад сангийн үйл ажиллагаа төрөөс хараат бус, улс төрийн болон шашны үйл ажиллагаанаас ангид байх, төрөөс үл ялгаварлах, тэгш боломж олгох, нээлттэй хэлбэрээр хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө хуулийн этгээдийн (сан) үйл ажиллагаа нийтлэгээр дэмжих, харилцах, хамтран ажиллах зарчим хэвээр хадгалагдахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

**ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ
ТОГТООСОН БАЙДАЛ**

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл. Төрийн мэдээлэл сэтгүүл 2015 оны №25

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5, 7, 13, 24, 25 дугаар зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн⁷ зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал⁸, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл Төрийн бус байгууллагын тухай хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

1. Сангийн эрх зүйн байдлыг Иргэний хуульд заасан ашгийн бус хуулийн этгээдийн төрөлд нийцүүлэн тодорхойлж, иргэд санг хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулахыг хуульчилна. Өөрөөр хэлбэл бүртгэлтэй ТББ-ын нэг хэлбэр нь “Сан”-ийн хэлбэрээр, харин хуулийн

⁷ Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл. www.mojha.gov.mn

⁸ Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал. 2021 он.

этгээдийн эрхгүй байгууллага нь Иргэний хуулийн хандивын гэрээний зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулахаар ялган зохицуулна;

2. Сангийн эрх зүйн байдлын онцлог зохицуулалтыг хуульчилна;

3. Сангийн эрх зүйн зохицуулалтыг хувийн сан, нийтийн сангийн 2 төрөлтэйгөөр ялгаатай байдлаар зохицуулна;

4. Сангийн зорилгын ач холбогдлыг чухалчлан, тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулна. Хуулиар сан нь өөрийн дүрэмдээ зорилгоо тодорхой заахаас гадна зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сангийн жишиг ангиллын дагуу тодорхойлсон байх, зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө, эсхүл санхүүжилтийн талаар тодорхой заах, төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхойлох, татан буугдсаны дараа хөрөнгийг хүлээн авах этгээдийг тодорхойлох гэх мэт шаардлагыг тогтооно;

5. Мөн сангийн дотоод засаглал, санхүүгийн зарцуулалтад ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хөрөнгө, орлого, ашгийг шууд ба шууд бусаар хандивлагч байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх одоогийн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэвээр хадгална;

6. Сангийн нөөц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, орлогыг дүрэмдээ заасан зорилгодоо зарцуулах нөхцөл, журмыг нарийвчлан тодорхойлно. Энэхүү аж ахуй үйл ажиллагаа нь сангийн гол зорилго, үндсэн үйл ажиллагаа байж болохгүй бөгөөд тодорхой хязгаартайгаар явуулах шаардлага, хязгаарлалтыг хуульчилна. Мөн сангийн хандив тусламж, аж ахуйн үйл ажиллагааны орлогоос гишүүд болон бусад этгээдэд ашиг хуваарилахыг хориглоно;

7. Санд үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг нэгдсэн журмаар татварын хууль тогтоомжид тусгаж зохицуулна. Энэ хүрээнд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны орлого нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарах бөгөөд хувь хүн, аж ахуй нэгжээс санд өгсөн хандивыг тодорхой хязгаарлалтын хүрээнд татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохоор зохицуулна;

8. Сангийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа бол тухайн үйл ажиллагаатай холбоотой санхүү, татвар, үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад гаргах, ил тод байлгах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Түүнчлэн сан нь төрийн байгууллага, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагуудаас санхүүжилт авсан бол санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тухайн гэрээ байгуулсан, санхүүжүүлсэн төрийн байгууллага, олон улсын

хөгжлийн байгууллагад хүргүүлэх, нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар зохицуулна;

9. Үйл ажиллагаа эрхэлж байгаа болон үйл ажиллагаагаа зогсоосон сангийн жагсаалтыг Иргэний нийгмийг дэмжих зөвлөлөөс ил тод хөтлөх, тэдгээрийг татан буулгах үндэслэл, журмыг тодорхой зохицуулахаас гадна хариуцлагын асуудлыг Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд нийцүүлэн тодорхойлно;

10. Шинэ хууль хүчин төгөлдөр болсонтой холбоотой шилжилтийн зохицуулалт, дагаж мөрдөх журмыг тусгана.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

- *Сангийн эрх зүйн байдлыг Иргэний хуульд заасан ашгийн бус хуулийн этгээдийн төрөлд нийцүүлэн тодорхойлж, иргэд санг хуулийн этгээдийн эрхтэй болон эрхгүйгээр байгуулан үйл ажиллагаагаа явуулахыг хуульчлах хүрээнд:*

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “сан”-г, мөн зүйлийн 4.1.2, 4.1.3-д “хувийн сан”, “нийтийн сан”-г тодорхойлсон байна.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т ашгийн бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршоо гэсэн хэлбэртэй байхаар, 36 дугаар зүйлийн 36.3-т сангийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар тогтоохоор заасан.

Ийнхүү Иргэний хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд хуулийн төсөлд иргэд хэд хэдэн этгээдээс, эсхүл олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэх замаар санхүүжилт авч үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийг сан байхаар зохицуулсан нь зүйтэй байна.

Харин бүртгэлгүй санг Иргэний хуулийн хандивын гэрээний дагуу явуулж болохоор заасан байна.

Түүнчлэн холбоо, сангаас бусад Иргэний хуульд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гуравдагч хэлбэр болох **хоршооны талаарх зохицуулалт тусгагдаагүй байна.**

Өөрөөр хэлбэл, хоршоог “ашиг олох” зорилготой хуулийн этгээдэд тооцон Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд томъёолсон байна.

Хоршоо нь иргэдээс нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дураараа нэгдсэн, дундын эд хөрөнгийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул шууд ашиг олох зорилготой хэмээн үзэж, ашгийн төлөөх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, зарчимд нийцэн ажиллах нөхцөлийг тулгаж болохгүй юм.

Иймд хоршоог ашгийн төлөө бус хуулийн этгээдийн хэлбэрээс хасах бус харин **Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.5-д** “Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.” гэсэнтэй **уялдуулан хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “хоршоо”-г нэмж тусгах шаардлагатай байна.**

○ *Сангийн эрх зүйн байдлын онцлог зохицуулалтыг хуульчлах хүрээнд:*

Хуулийн төслийн үзэл баримтлалд Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулахдаа сангийн эрх зүйн байдлын онцлог зохицуулалтыг хуульчлахаар заасан байна.

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлд сангийн санхүүжилтийн хэлбэрээс хамаарч санг нийтийн сан, хувийн сан гэж зөвхөн хоёр төрөлтэй байхаар заасан байна.

Харин хуулийн төсөлд энэ хоёр төрлөөс өөрөөр сангийн онцлог зохицуулалтыг нарийвчлан тусгаагүй байна.

Иймд Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасан сангийн онцлог зохицуулалтын талаар хуулийн төсөлд нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

○ *Сангийн эрх зүйн зохицуулалтыг хувийн сан, нийтийн сангийн 2 төрөлтэйгөөр ялгаатай байдлаар зохицуулах хүрээнд:*

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1-д сан нь санхүүжилтийн хэлбэрээс хамаарч нийтийн, хувийн гэсэн төрөлтэй байхаар, мөн зүйлийн 9.2-т хувийн сан нь олон нийтээс хөрөнгө төвлөрүүлэхийг хориглох, 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “нийтийн сан” гэж олон нийтээс болон бусад этгээдээс хөрөнгө төвлөрүүлэх замаар санхүүжилт авч үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээд байхаар заасан байна.

Түүнчлэн хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т хувийн санг байгуулахад үүсгэн байгуулагч нь 10 сая түүнээс дээш төгрөгийг сангийн дансанд байршуулсан байх бөгөөд 9.5-д зааснаар нэг этгээд санг үүсгэн байгуулж болохоор заасан бол 9.4-т нийтийн сан нь жил тутам санхүүгийн тайландаа аудит хийлгэх шаардлагыг тогтоосон байна.

Үүнээс дүгнэхэд сан нь санхүүжилтийн хэлбэрийн хувьд хувийн болон нийтийн сан гэсэн 2 төрөлтэй байх бөгөөд нийтийн сан нь олон нийтээс хандив төвлөрүүлж санхүүжилтийг бүрдүүлэхээр нээлттэй байгаагийн хувьд жилийн тайландаа аудит хийлгэх зэргээр хувийн сангаас илүү шаардлагыг зохицуулж өгсөн байна. Өөрөөр хэлбэл нийтээс хөрөнгө төвлөрүүлж үндсэн зорилгоо хэрэгжүүлэх тул хувийн сангаас илүү шаардлагыг тавьсан байна. Энэ нь нийтийн сангийн үйл ажиллагаа санхүүжилтэд хяналт тавих үндсэн шалгуурын нэг болохоор байна.

Түүнчлэн нэг этгээдийн үүсгэн байгуулсан хувийн сангийн дүрмийг тухайн үүсгэн байгуулагчийн шийдвэрээр өөрчилж болохоор нарийвчлан заасан байна.

Нийтийн сан нь олон нийтээс хөрөнгө төвлөрүүлдэгийн хувьд хамтын удирдлагаар шийдвэр гаргах, санхүүгийн хяналтыг бий болгох хүрээнд заавал хяналтын хороотой байх шаардлагыг хуульчилж өгөх нь зүйтэй байна.

- *Сангийн зорилгын ач холбогдлыг чухалчлан, тавигдах шаардлагыг нарийвчлан зохицуулна. Хуулиар сан нь өөрийн дүрэмдээ зорилгоо тодорхой заахаас гадна зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг олон улсын сангийн жишиг ангиллын дагуу тодорхойлсон байх, зорилгыг хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө, эсхүл санхүүжилтийн талаар тодорхой заах, төлөөлөх эрх бүхий этгээдийг тодорхойлох, татан буугдсаны дараа хөрөнгийг хүлээн авах этгээдийг тодорхойлох гэх мэт шаардлагыг тогтооно хүрээнд:*

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д сан нь дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд сангийн нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрүүлэхгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болох, 5.6-д сан нь аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд зарцуулахаар заасан. Мөн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2-д сан нь өөрийн дүрэмд заасан үйл ажиллагааны зорилго, чиглэлтэй уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй болон төлбөргүйгээр эрхлэн гүйцэтгэж болохоор заасан.

Түүнчлэн сангийн санхүүжилтийн нэг эх үүсвэр болох аж ахуйн үйл ажиллагаа, эсхүл нийтэд тустай үйл ажиллагааны **төлбөртэй үйлчилгээ үзүүлэх хэлбэр нь зөвхөн дүрмэнд заасан зорилгод шууд холбоотой байх** шаардлагыг тусгахын зэрэгцээ сан нь **үндсэн зорилгоо өөрчлөн ашгийн төлөө хуулийн этгээд болж өөрчлөн байгуулагдахыг хориглосон** байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д дүрэмдээ заасан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд сангийн нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрүүлэхгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохоор заасан байна. Өөрөөр хэлбэл тухайн хуулийн хязгаарт аж ахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлж болох бөгөөд энэхүү хязгаараас давсан тохиолдолд үндсэн зорилгоо өөрчилсөн, ашгийн байгууллага болсонд тооцно.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж, ашгийн төлөө ажиллахыг хориглохоор заасан.

Сан нь аж ахуйн үйл ажиллагааны чиглэл зорилгыг заавал дүрэмдээ тусгах, сангийн эрх бүхий байгууллага аж ахуйн үйл ажиллагааг явуулах шийдвэр гаргах ёстой байна.

Түүнчлэн хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.1-д нийтэд тустай үйл ажиллагааг мөн сангийн зорилго, чиглэлдээ уялдуулан явуулахаар заасан.

Үүнээс дүгнэхэд сан нь үндсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ дүрмэндээ тодорхой тусгах бөгөөд энэ нь цаашид тухайн сангийн үйл ажиллагаа, санхүүжилтэд хяналт тавих үндсэн шалгуурын нэг болохоор байна.

Энэхүү зохицуулалт нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд төрийн бус байгууллагын зорилгыг үйл ажиллагааны чиглэлээр зааглан тодорхойлоогүй, үйл ажиллагааны чиглэлийг нь зорилго гэж үзэх, түүнчлэн зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянах боломжийг хязгаарладаг зэрэг алдааг засах дэвшилттэй зохицуулалт болсон байна.

Харин хуулийн төсөлд сангийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилгыг нийтлэг байдлаар тусгаж, түүний нийтлэг зохицуулалтыг тусгах эсэх талаар хэлэлцэх нь зүйтэй. Одоогоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 1664 сан бүртгэлтэй байгаа бөгөөд тэдний үйл ажиллагааны зорилго чиглэлийг нийт 19 чиглэлд хуваасан байдаг.

Хуулийн төслийг дагалдан Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд “орлогоо дүрэмдээ зааснаас өөр зорилгоор зарцуулсан”, “үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан” үйлдлийг зөрчилд нэмж тооцохоор тусгасан байна.

Гэтэл хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д аж ахуйн үйл ажиллагаа нь сангийн нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрэхгүй байх, 5.2-т аж ахуйн үйл ажиллагаа нь 20 хувиас хэтэрсэн тохиолдолд үндсэн зорилгоо өөрчилсөнд тооцох буюу ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсанд тооцохоор заасан бөгөөд 20 хувийг хэрхэн тооцох нь тодорхойгүй, үүнээс үүсэх үр дагавар нь хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 24 дүгээр зүйлийн 24.1.3-т зааснаар татан буугдах үндэслэл болохоор заасан байна. Энэ нь нэг талаар тухайн сангийн үйл ажиллагааг үндсэн зорилго, чиглэлд нийцүүлэх, ашгийн төлөө бус байгууллагын гол зарчим болох ашгийн үйл ажиллагааг явуулахгүй байхад чиглэсэн үйл ажиллагааг голчлох хэдий боловч хуулийн дээрх хатуу заалтаас үүдэн сан татан буугдахад хүрэхээр байна.

Түүнчлэн сангийн санхүүжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх боломж бага байгааг харгалзан аж ахуйн үйл ажиллагаа явуулах зэргээр сангийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг хязгаарлаж болзошгүй байна.

Иймд сангийн эрхлэн явуулах аж ахуйн үйл ажиллагааг 20 хувиар хязгаарлахдаа тодорхой хэмжээгээр хэтэрсэн тохиолдолд татварын арга хэрэглэх, дараагийн удаад татан буугдах үндэслэл болох зэргээр шаталсан байдлаар зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл сангийн үндсэн үйл ажиллагааны нийлбэрээс 20-50 хувиар аж ахуйн үйл ажиллагаа хэтэрсэн бол тухайн хэтэрсэн аж ахуйн үйл ажиллагаанд татвар ногдуулах, харин 50 дээш

хувиар хэтэрсэн бол татан буугдах үндэслэл болохоор зохицуулалтыг нарийвчлан ялгавартай байдлаар тусгах нь зүйтэй байна.

Гэвч хуулийн төслийн 6 дугаар зүйлийн 6.5 болон 11.1-д “хууль буюу дурмэндээ зааснаар бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэсэн нь сангийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан шинжтэй, мөн санхүүжилт босгох хэлбэр болох “төлбөртэй үйлчилгээ нь дүрэмд заасан зорилгод шууд хамаарсан байх” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, зөрчсөн нөхцөлд дүрэмд заасан зорилгоос гадуур аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэх эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, “аж ахуйн үйл ажиллагааны орлогыг дүрэмд зааснаас бусад зорилгоор ашиглах” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг

- зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;
- хувийн сангийн үүсгэн байгуулагчийн байршуулсан хөрөнгө;
- хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж;
- нийтийн санд олон нийтээс төвлөрүүлсэн хөрөнгө;
- зорилго чиглэлтэй уялдуулсан нийтэд тустай үйл ажиллагаа явуулсны нь төлөө төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;
- иргэний нийгмийг дэмжих сангаас үзүүлсэн мөнгөн тусламж;
- санд өвлөж авсан өв;
- бусад эх үүсвэр гэж заасан байна.

Сангийн явуулах аж ахуйн үйл ажиллагаа нь “зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой” байх шаардлага тавигдаж байгаа бөгөөд үүнийг урьдчилан хэрхэн тогтоох нь эргэлзээтэй төдийгүй энэхүү зохицуулалтаар тавьж буй хязгаарлалт нь хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2-т заасан аж ахуйн үйл ажиллагааг ашиг олоход биш дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эрхлэх нь хуулийн 5.5-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж олсон орлогыг дүрмийн зорилгод нийцүүлэн зарцуулах гэсэн агуулгатай давхардаж байгааг анхаарах.

Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдлийг бусниулах, экстремист үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүнээс болон хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглосон нь хууль бус үйл ажиллагаанд оролцох эрсдэлийг бууруулах, хяналтыг нэмэгдүүлэх сайн талтай бөгөөд террорист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүний талаарх мэдээллийг цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх газар гаргаж, нээлттэй мэдээлэхээр заасан боловч хэдийн хэр хугацаанд тухайн мэдээллийг шинэчлэх, хандивлагч нь тодорхойгүй, эсхүл дээрх жагсаалтад орсон этгээдээс санхүүжилт орж ирсэн тохиолдолд хэрхэх талаар тодорхойгүй байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хуулиар сан нь мэдээлэх үүрэгтэй этгээд болохгүй бөгөөд 20 сая төгрөгөөс дээш хандив тусламжийн талаар мэдээлэх үүрэг хүлээхгүй тул хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт, халхавч байгууллага болон үндэсний эв нэгдэлийг бусниулах, экстремист үйл ажиллагаа

явуулдаг байгууллага, хувь хүнээс болон хандивлагч нь тодорхойгүй санхүүжилтийн талаар мэдээлэх үүргийг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-д санг төлөөлөх эрх бүхий этгээдийг гүйцэтгэх захирал байхаар тодорхойлж, түүний эрх хэмжээг хуулийн төслийн 20 дугаар зүйлд заасан байна.

Гэхдээ хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.2.1-д гүйцэтгэх захирлын эрх хэмжээг сангийн удирдах зөвлөлөөс тогтоохоор заасан байна.

Харин хуулийн төсөлд сангийн удирдах зөвлөл нь сангийн гүйцэтгэх захирлыг томилох, түүний эрх хэмжээг тогтоохоор заасан бөгөөд хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д гүйцэтгэх захирал санг төлөөлөхөөр заасан боловч уг хэсэгт “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн нөхцөлийг тусгасан.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь хуулийн төсөл болон төслийн үзэл баримтлалд зааснаар сангийн эрх зүйн байдал, түүний бүртгэл, тайлагналт, үйл ажиллагаатай холбоотой нийтлэг харилцааг зохицуулах гол хууль бөгөөд Иргэний хуульд заасан ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэг төрөл болохыг нарийвчлан заасан. Мөн Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т сангийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулахаар заасан болно.

Иргэний хууль болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулиас бусад хуульд сантай холбоо тэр дундаа санг төлөөлөх этгээдийн талаар заахгүй бөгөөд хуулийн хүрээн хязгаарт нийцэхгүй юм.

Иймд Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол” гэсэн хэсгийг хасах нь зүйтэй байна.

Дараагийн нэг чухал асуудал нь сан татан буугдсаны дараах эд хөрөнгийн зохицуулалт бөгөөд хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.2-д татан буугдаж байгаа сангийн эрх барих байгууллага нь үлдсэн хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн санд шилжүүлэхээр шийдвэрлэж болохоор заасан байна.

Мөн зүйлийн 25 дугаар зүйлийн 25.3-т дээрх шийдвэр гараагүй бол ижил зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн санд шилжүүлэх, эсхүл сангийн зорилгод ижил үйл ажиллагаанд зарцуулахаар иргэний нийгмийг дэмжих санд шилжүүлэхээр заасан.

Харин хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу шаардах эрх бүхий харилцагчийн үүргийн гүйцэтгэлийг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг бусадад хуваарилан олгохыг хориглохоор заасан байна.

Дээрх зохицуулалтаас дүгнэж үзэхэд хуулийн төслийн 25 дугаар зүйлд сан татан буугдах үеийн эд хөрөнгийн зохицуулалтыг хувийн сан, эсхүл нийтийн сан

алин болохыг үл хамааран татан буугдсаны дараах эд хөрөнгийн зохицуулалтыг хоёр хэлбэрээр шийдвэрлэсэн байна.

Нэгд сан татан буугдахдаа эд хөрөнгөө дүрэмдээ заасан ижил зорилгод нийцсэн ижил төстэй нэг, эсхүл хэд хэдэн санд шилжүүлэх шийдвэр гаргаж шилжүүлэх,

Хоёрт эд хөрөнгөө шилжүүлэх шийдвэрийг сангийн эрх барих байгууллага гаргаагүй тохиолдолд Иргэний нийгмийг дэмжих зөвлөлийн саналыг харгалзан татан буугдах комисс нэг, эсхүл хэд хэдэн ижил зорилго бүхий санд, иймд этгээд байхгүй тохиолдолд Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих санд шилжүүлэхээр зохицуулсан.

Энэ нь тухайн сан нь ашгийн төлөө бус хуулийн этгээд болох нэг чухам зарчим болно. Өөрөөр хэлбэл тухайн сангийн оруулсан үүсгэн байгуулагчийн хөрөнгө, хандив тусламж нь тухайн сангийн өмч хөрөнгө болохоос сангийн үүсгэн байгуулагч, гишүүдийн хөрөнгө биш бөгөөд эд хөрөнгө, орлогоос гишүүдэд ашиг хуваарилахгүй байх үндсэн зарчим болно.

Түүнчлэн энэ зүйлд сангийн эд хөрөнгөөс шаардах эрх бүхий харилцагчийн үүргийн гүйцэтгэлийг хангасны дараа эд хөрөнгийг шилжүүлж болох, мөн дүрэмдээ заасан ижил зорилгод нийцсэн санд шилжүүлэх зэрэг хоёр шаардлагыг тодорхой заасан байна.

Харин энэ зүйлд хоёр зохицуулалтыг анхаарах нь зүйтэй байна.

-Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д эд хөрөнгийг бусдад хуваарилан олгохыг хориглохоор заасан байна. Гэтэл мөн зүйлийн 25.2-т татан буугдаж байгаа сангийн эрх барих байгууллага нь үлдсэн хөрөнгийг ижил зорилго бүхий нэг, эсхүл хэд хэдэн санд шилжүүлэхээр шийдвэрлэж болохоор заасантай зөрчилдөхөөр байна. Өөрөөр хэлбэл 25.1-д бусдад шилжүүлэхийг хориглоно гэж заасан боловч дараагийн хэсэгт (25.2)-т хуваарилж болохоор заасан байна.

Иймд уг зөрчлийг арилгах үүднээс хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1-д “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж нэмэх зэргээр, эсхүл “энэ зүйлийн 25.2, 25.3-т зааснаас бусад тохиолдолд гэж” эсхүл тухайн хуваарилан олгохыг хориглох нөхцөлийг тодотгож болно.

-Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.2-т сангийн эд хөрөнгийг сангийн эрх барих байгууллага хэнд шилжүүлэхийг шийдвэрлэж болно. Харин тухайн шийдвэр гараагүй, татан буугдаж байгаа сантай ижил зорилго, чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг олон сан байгаа тохиолдолд эд хөрөнгийг хэрхэн хуваарилах талаарх зохицуулалт тодорхойгүй байна.

Иймд тухайн татан буугдах комисс баримтлах зарчмыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

○ сангийн дотоод засаглал, санхүүгийн зарцуулалтад ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, хөрөнгө, орлого, ашгийг шууд ба шууд бусаар хандивлагч байгууллагын удирдах зөвлөлийн гишүүдийн хувийн ашиг сонирхолд ашиглахгүй байх, сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийг сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх одоогийн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэвээр хадгалах хүрээнд:

Сан нь ашгийн төлөө бус хуулийн этгээд байхын хувьд дотоод засаглалтай байхыг чухалчилж, сангийн үүсгэн байгуулагч, гишүүн, удирдах зөвлөл болон хяналтын хорооны гишүүд сангийн эд хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, хувийн ашиг сонирхолдоо зарцуулах зэрэг дүрэмд заагаагүй санхүүжилт хийхийг хориглохоор заасан байна.

Ингэж заахдаа хувийн сан, нийтийн сангийн эрх зүйн байдлыг ялгамжтайгаар заасантай адилаар дотоод засаглал, бүтэц, хэлбэрийн хувьд нийтийн болон хувийн санг онцлогийг гаргаж заасан байна.

Тухайлбал, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4-т санг нэг этгээд үүсгэн байгуулах бол удирдах зөвлөл, хяналтын хороогүй байж болох бөгөөд сан удирдах зөвлөл, хяналтын хороотой байх эсэхийг сангийн үүсгэн байгуулагч шийдвэрлэхээр заасан.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.5-д сангийн үүсгэн байгуулагч нэг этгээд байгаа бөгөөд удирдах зөвлөл, хяналтын хороогүй бол байхаар шийдвэрлэсэн бол хяналтын хороо, удирдах зөвлөлийн бүрэн эрхийг үүсгэн байгуулагч дангаар хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл сангийн үүсгэн байгуулагч нь Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлд заасан удирдах зөвлөлийн бүрэн эрх, 19 дүгээр зүйлд заасан сангийн хяналтын хорооны бүрэн эрхийг эдэлнэ.

Мөн хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу сангийн үүсгэн байгуулагч нь нэг байх бөгөөд удирдах зөвлөлгүй байхаар шийдвэрлэсэн бол үүсгэн байгуулагч нь сангийн эрх барих байгууллага байна.

Энэ бүхнээс дүгнэхэд санг нэг этгээд үүсгэн байгуулах тохиолдолд үүсгэн байгуулагчийн эрх хэмжээний дагуу удирдах зөвлөл болон хяналтын хороогүй байж болохоор байна. Энэхүү зохицуулалт нь хувийн санд илүү тохиромжтой бөгөөд харин нийтийн сангийн хувьд тохиромжгүй юм. Өөрөөр хэлбэл нийтийн сан нь олон нийтээс санхүүжилт төвлөрүүлэх бөгөөд уг санхүүжилтийг зарцуулах шийдвэрийг хуулийн төслийн 18 дугаар зүйлд заасны дагуу удирдах зөвлөлөөс гаргаж байх нь илүү үр дүнтэй ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, санхүүжилтийг сангийн дүрэмд заасны дагуу зарцуулахад хяналттай, үр дүнтэй бөгөөд хуулийн төслийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хяналтын хороо нь сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих юм.

Түүнчлэн хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-т сан нь хяналтын хороо болон сангийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах гүйцэтгэх захиралтай байхаар

заасан нь хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4-т нэг этгээд санг үүсгэн байгуулахаар бол удирдах зөвлөл болон хяналтын хороогүй байж болох, удирдах зөвлөл, хяналтын хороогүй байх эсэхийг сангийн үүсгэн байгуулагч шийдвэрлэхээр заасантай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл хуулийн төслийн 11.4-т хяналтын хороогүй байж болохоор заасан бол 14.2-т заасан хяналтын хороо, гүйцэтгэх удирдлагатай байхаар заасан байна.

Иймд хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.2-т **“хуульд өөрөөр заагаагүй бол”, эсхүл “энэ хуулийн 11.4-т зааснаас бусад тохиолдолд”** гэж тодотгох нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасан нэг этгээд санг үүсгэн байгуулах тохиолдолд гүйцэтгэх захиралтай байх эсэх нь, мөн хувийн сан болон нийтийн санд удирдах зөвлөл, хяналтын хороо, гүйцэтгэх удирдлагатай байх эсэх нь тодорхойгүй байна.

Иймд хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4-т заасан нэг этгээд сангийн үүсгэн байгуулагч байх тохиолдолд гүйцэтгэх захиралтай байх эсэх, нийтийн санд удирдах зөвлөл, хяналтын хороо, гүйцэтгэх удирдлага заавал байх зохицуулалтыг нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

Дараагийн нэг чухал асуудал нь сангийн гишүүдийн ашиг сонирхлын байдал бөгөөд сангийн эд хөрөнгийг хувийг ашиг сонирхолд, эсхүл зорилгодоо нийцээгүй үйл ажиллагааг санхүүжүүлэхийг Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр хориглосон байна.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх, 7.1.3.сангийн гишүүдэд аливаа хэлбэрээр ашиг хуваарилах, 7.1.4-т шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, 7.1.5-д сангийн эд хөрөнгийн дүрэмд заасан зорилгоос бусад зориулалтаар зарцуулах, бусдад зээлдүүлэх, барьцаалах, сангийн удирдлага, ажилтны ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглохоор заасан.

Хэрэв уг хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасны дагуу хуулийн төслийн 7.1.1, 7.1.3-т заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан бол тухайн санг татан буулгах үндэслэл болох бол 7.1.4-т заасан шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үйл ажиллагааг явуулсан бол Зөрчлийн тухай хуульд заасан торгох арга хэмжээг авахаар заасан байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4, 7.1.5-т заасан хориглосон үйл ажиллагаа нь бүгд сангийн санхүүжилтийг дүрэмд зааснаас өөр зорилгоор ашигласан, санхүүжүүлсэн үйл ажиллагаа болохоор байна. Харин хуулийн төслийн 24 дүгээр зүйлд зааснаар улс төрийн намын үйл ажиллагааг, улсын төрийн нам, шашны байгууллага, шашны үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь мөн адил сангийн

дүрэмд зааснаас бусад зорилгоор сангийн эд хөрөнгийг зарцуулсанд тооцогдохоор байна.

Харин тухайн дээрх улс төрийн нам, шашны байгууллага, тэдний үйл ажиллагааг санхүүжүүлэх нь сангийн үндсэн зорилгодоо нийцээгүй үйл ажиллагааг санхүүжүүлэх болохыг анхаарах.

○ *Сангийн нөөц, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахад анхаарч, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх, орлогыг дүрэмдээ заасан зорилгодоо зарцуулах нөхцөл, журмыг нарийвчлан тодорхойлно. Энэхүү аж ахуй үйл ажиллагаа нь сангийн гол зорилго, үндсэн үйл ажиллагаа байж болохгүй бөгөөд тодорхой хязгаартайгаар явуулах шаардлага, хязгаарлалтыг хуульчилна. Мөн сангийн хандив тусламж, аж ахуйн үйл ажиллагааны орлогоос гишүүд болон бусад этгээдэд ашиг хуваарилахыг хориглох хүрээнд;*

Сангийн санхүүжилтэд төрөөс дэмжлэг үзүүлэх боломж бага байгааг харгалзан аж ахуйн үйл ажиллагаа явуулах зэргээр сангийн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

Хуулийн төслийн 13 дугаар зүйлд сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг

➤ зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

➤ хувийн сангийн үүсгэн байгуулагчийн байршуулсан хөрөнгө;

➤ хувь хүн, байгууллагаас өгсөн хандив, тусламж;

➤ нийтийн санд олон нийтээс төвлөрүүлсэн хөрөнгө;

➤ зорилго чиглэлтэй уялдуулсан нийтэд тустай үйл ажиллагаа явуулсны нь төлөө төрөөс үзүүлсэн мөнгөн болон бусад хэлбэрийн санхүүгийн дэмжлэг;

➤ иргэний нийгмийг дэмжих сангаас үзүүлсэн мөнгөн тусламж;

➤ санд өвлөж авсан өв;

➤ бусад эх үүсвэр гэж заасан байна.

Хуулийн төсөлд Сангийн санхүүжилтийн эх үүсвэрийг одоогийн Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэн тогтоосон бөгөөд санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах хүрээнд санг өөрийн зорилгодоо нийцсэн, үндсэн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг явуулж болохоор мөн нийтэд тустай үйл ажиллагааг төлбөртэй явуулж болохоор заасан байна.

Тухайлбал, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д сан нь дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд сангийн нийт үйл ажиллагааны 20 хувиас хэтрүүлэхгүй аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болох, 6 дугаар зүйлийн 6.1-д сан нь өөрийн дүрэмд заасан үйл

ажиллагааны зорилго, чиглэлтэй уялдуулан нийтэл тустай үйл ажиллагааг төлбөртэй болон төлбөргүй эрхлэн гүйцэтгэж болохоор тус тус заасан байна.

Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д сангийн явуулж болох аж ахуйн үйл ажиллагаанд 20 хувийн хязгаарлалтай явуулах болон тухайн аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг зөвхөн дүрэмдээ заасан зорилго, үйл ажиллагааг санхүүжүүлэхээр мөн зүйлийн 5.6-д заасан байна.

Дээрх зохицуулалтаас үзэхэд хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хоёр хязгаарлалтыг тогтоосон бөгөөд аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж олсон орлогоо зөвхөн дүрэмдээ заасан зорилго үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан нь тухайн сангийн үйл ажиллагааг илүү үндсэн зорилго үйл ажиллагааг дэмжихэд шууд чиглэсэн хязгаарлалт болно.

Харин аж ахуйн үйл ажиллагааг явуулахдаа үндсэн үйл ажиллагааны 20 хувийг хэтрүүлэхгүй байхаар заасан байна. Энэ нь хэдийгээр ашгийн төлөө бус хуулийн этгээд болохыг тодотгож, ашгийн төлөө үйл ажиллагаанаас ангид байхыг чухалчилсан хэдий боловч хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.5-д заасан татан буугдах үндэслэл болохоор байгаа нь хэтэрхий хатуу нөхцөлийг тусгасан байна.

Иймд сангийн аж ахуйн үйл ажиллагааг 20 хувиар хязгаарлахдаа тодорхой хэмжээгээр хэтэрсэн тохиолдолд татварын арга хэрэглэх, дараагийн удаад татан буугдах үндэслэл болох зэргээр шаталсан байдлаар зохицуулалтыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл сангийн үндсэн үйл ажиллагааны нийлбэрээс 20-50 хувиар аж ахуйн үйл ажиллагаа хэтэрсэн бол тухайн хэтэрсэн аж ахуйн үйл ажиллагаанд татвар ногдуулах, харин 50 дээш хувиар хэтэрсэн бол татан буугдах үндэслэл болохоор зохицуулалтыг нарийвчлан ялгавартай байдлаар тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн хуулийн төслийн 6.5 болон 11.1-д “хууль буюу дүрэмдээ зааснаар бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэсэн нь төрийн бус байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан шинжтэй, мөн санхүүжилт босгох хэлбэр болох “төлбөртэй үйлчилгээ нь дүрэмд заасан зорилгод шууд хамаарсан байх” гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, зөрчсөн нөхцөлд дүрэмд заасан зорилгоос гадуур аж ахуйн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэх эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, “аж ахуйн үйл ажиллагааны орлогыг дүрэмд зааснаас бусад зорилгоор ашиглах” гэж өөрчлөх нь зүйтэй байна.

Сангийн явуулах аж ахуйн үйл ажиллагаа нь “зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой” байх шаардлага тавигдаж байгаа бөгөөд үүнийг урьдчилан хэрхэн тогтоох нь эргэлзээтэй төдийгүй энэхүү зохицуулалтаар тавьж буй хязгаарлалт нь хуулийн төслийн 5.1, 5.2-т заасан аж ахуйн үйл ажиллагааг ашиг олоход биш дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд эрхлэх нь хуулийн 5.5-д заасан аж ахуйн үйл ажиллагааг эрхэлж олсон орлогыг дүрмийн зорилгод нийцүүлэн зарцуулах гэсэн агуулгатай давхардаж байгааг анхаарах.

- *Санд үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг нэгдсэн журмаар татварын хууль тогтоомжид тусгаж зохицуулна. Энэ хүрээнд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагааны орлого нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамаарах бөгөөд хувь хүн, аж ахуй нэгжээс санд өгсөн хандивыг тодорхой хязгаарлалтын хүрээнд татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцохоор зохицуулах хүрээнд:*

Санд үзүүлэх татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хүрээнд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 4.1.3-т нийтэд тустай үйл ажиллагаа гэдгийг Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөс эшлэн оруулсан бөгөөд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.10-т ашгийн төлөө бус хуулийн этгээдийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотой олсон аж ахуйн болон нийтэд тустай үйл ажиллагааны орлогыг татвараас чөлөөлөхөөр тусгасан байна.

Өөрөөр хэлбэл Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дагах Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр сангийн аж ахуйн болон нийтэд тустай үйл ажиллагааны орлогыг татвараас чөлөөлөхөөр заасан байна.

Харин Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7, 15.1.8-д заасан хөгжлийн бэрхшээлтэй хүний үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус хуулийн этгээд, спортыг дэмжих санд өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандивыг татвар ногдох орлогоос хасахаар зааснаас бусад хандив өгсөн иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас өгсөн хандивыг татвар ногдох орлогоос хасаж тооцохоор заагаагүй байна. Сангийн хөрөнгөө бүрдүүлэх санхүүжилтийн үндсэн хэлбэр нь хандив тусламж бөгөөд санхүүжилтийн тогтвортой байдлыг бий болгоход сангийн хандив тусламжийг татвараас чөлөөлөх, хөнгөлөх хөшүүрэг юм.

Иймд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ашгийн төлөө бус хуулийн этгээдэд өгсөн хандивыг орлогын албан татвар ногдох орлогоос хасах зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

Түүнчлэн орлогын албан татвараас гадна гадаад улсын иргэн, байгууллагаас хандивласан эд хөрөнгөд гаалийн албан татвар болон бусад төрлийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

- *Сангийн хариуцлагыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа ил тод байх зарчмыг хэрэгжүүлэхэд анхаарч нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж, татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж байгаа бол тухайн үйл ажиллагаатай холбоотой санхүү, татвар, үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад гаргах, ил тод байлгах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.*

Түүнчлэн сан нь төрийн байгууллага, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагуудаас санхүүжилт авсан бол санхүүгийн болон үйл

ажиллагааны тайланг тухайн гэрээ байгуулсан, санхүүжүүлсэн төрийн байгууллага, олон улсын хөгжлийн байгууллагад хүргүүлэх, нийтэд ил тод нийтлэх үүрэгтэй байхаар зохицуулна:

Хуулийн төслийн 12 дугаар зүйлд сангийн тайлагнах үүрэгтэй холбоотой зохицуулалтыг тусгасан байна.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.2-т “сан нь хууль, дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа тайлагнана.” гэсэн нь тайлагнах үүргээ хэрэгжүүлэхдээ хууль, дүрмийн аль алийг баримтлах боломжтой байна.

Түүнчлэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жилд нэг удаа гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй байна. Мөн энэхүү сан нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа олон нийтэд нээлттэй байлгах үүргийг хуулийн төслөөр хүлээж байна.

Хуулийн төслийн 12 дугаар зүйлийн 12.2-т нийтэд тустай үйл ажиллагаа эрхэлж байгаа хувийн болон нийтийн сан нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа дараа жилийн эхний улиралд багтаан Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлд хүргүүлэхээр заасан бол бусад үйл ажиллагаа явуулдаг сан нь үйл ажиллагааны тайлангаа Иргэний нийгмийг дэмжих зөвлөлд гаргаж өгөх нь сайн дурын байна.

Харин татварын болон санхүүгийн тайлангаа холбогдох бусад байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргаж өгөх үүрэгтэй.

Сан нь төрийн байгууллага, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагаас санхүүжилт авсан бол санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг тухайн гэрээ байгуулсан, санхүүжилт өгсөн төрийн байгууллага, олон улсын хөгжлийн байгууллагад хүргүүлэх, нийтэд ил тод нийтлэх үүргийг хуулийн төсөлд тусгайлан тусгаж өгөөгүй байна.

Харин энэ төрлийн зохицуулалтыг сан нь өөрийн дүрэмдээ тусгаж болох хэдий боловч хуульд тусгасан тохиолдолд илүү үр дүнтэй болно.

Иймд хуулийн төслийн 12 дугаар зүйлд төрийн байгууллагаас, эсхүл олон улсын хөгжлийн байгууллагаас санхүүжүүлсэн бол тухайн байгууллагад тайлагнах, тайлангаа нээлттэй ил тод байлгахтай холбогдсон зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

- Шинэ хууль хүчин төгөлдөр болсонтой холбоотой шилжилтийн зохицуулалт, дагаж мөрдөх журмыг тусгах талаар:

Хуулийн төслийн 26 дугаар зүйлд тус хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд багтаан санг улсын шинэчилсэн бүртгэлд хамрагдах шаардлагыг тусгасан байна.

2020 оны 8 дугаар сарын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээгээр Монгол Улсад 1762 сан үйл ажиллагаа явуулж байна.⁹

Тухайлбал, 2018 онд батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд хуулийн этгээдийн шинэчилсэн бүртгэлийг тус хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд багтаан хамрагдахаар заасан байна.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Хуулийн төслийн 7, 12 дугаар зүйлд заасан зохицуулалтуудыг **“Практикт хэрэгжих боломж”** шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдэлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилоо.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төрийн байгууллага болон иргэд, төрийн бус байгууллага, судлаачдын төлөөлөлтэй уулзаж, санал хүсэлтийг авсан.

Мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

➤ Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн зохицуулалт:

Хуулийн төслийн 7 дугаар зүйлээр сан нь дараах үйл ажиллагааг явуулахыг хориглосон байна:

- улс төрийн нам, улс төрийн намын байгууллагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тэдгээрийг санхүүжүүлэх;
- шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэх;
- үндсэн зорилгоо өөрчилж ашгийн төлөө ажиллах, аливаа хэлбэрээр ашиг хуваарилах;
- улс төрийн нам, улс төрийн хөдөлгөөн болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигчид эд хөрөнгийн болон бусад хэлбэрээр хандив өгөх;
- сангийн эд хөрөнгийг дүрэмд заасан зорилгоос бусад зориулалтаар зарцуулах, бусдад зээлдүүлэх, барьцаалах, сангийн удирдлага, ажилтны ашиг сонирхлын төлөө ажиллах;
- татварын ашиг хүртэх үндсэн зорилгоор Татварын ерөнхий хуулийн 16.1.1-д заасан татварын схем дангаараа болон бусад этгээдтэй хамтран зохион байгуулах;

⁹ Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн танилцуулга. 2021 он. ХЗДХЯ

- нэргүй дугаарласан, эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглан;
- зохицуулалтгүй санхүүгийн сувгаар мөнгөн гүйлгээ хийх;
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14.2-т заасан үйл ажиллагаа болон тэдгээр этгээдтэй харилцаа холбоо тогтоох, санхүүжилт авах зэрэг үйл ажиллагааг явуулах;
- хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах;
- хуулиар хориглосон бусад.

Энэхүү хориглолтод заасан шашны үйл ажиллагаа явуулах, ашгийн төлөө ажиллах болон ногдол ашиг хуваарилахгүй байх, сонгуулийн үйл ажиллагаанд хандив өгөхгүй байх зэрэг нь өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Төрийн бус байгууллагын тухай хууль, Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль, Сонгуулийн хуулиар тус тус хориглогдсон байх тул практикт үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой.

Гэхдээ хуулийн төсөлд ирүүлсэн саналаас үзэхэд төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д **зохицуулалтгүй санхүүгийн сувгаар мөнгөн гүйлгээ хийхийг хориглосон зохицуулалтыг илүү нарийвчлах, эсхүл нэр томьёоны тайлбар хийх шаардлагатай гэж үзсэн байна.**

Өөрөөр хэлбэл зохицуулалттай санхүүгийн суваг гэдэгт санхүү, банкны ямар бүтээгдэхүүнийг оруулах, зохицуулалтгүй сувагт ямар санхүү банкны ямар бүтээгдэхүүнийг оруулах талаар тодорхойгүй байна. Зохицуулалттай, зохицуулалтгүй санхүүгийн сувгийн талаар энэ чиглэлийн мэргэжлийн хүмүүс ойлголттой байхаас бусад эвлэлдэн нэгдэх эрхээ хангаж, сан байгуулж байгаа иргэд тэр бүх мэдэхгүй.

Мөн хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасан “татварын схем зохион байгуулах” талаар мэргэжлийн хүмүүс ойлголттой байхаас сан байгуулж байгаа иргэд тэр бүр энэ талаар ойлголт байхгүй.

Үүнээс дүгнэхэд “зохицуулалтгүй санхүүгийн суваг”, “татварын схем” зэргийг тодруулах, эсхүл өөр энгийн томьёоллоор оруулах нь зүйтэй байна.

3. Ойлгомжтой эсэх:

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Мөн хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ойлгомжтой болгох чиглэлээр ирүүлсэн санал байгаа эсэхийг нягтлан, анализ хийсэн болно.

Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хууль дахь сангийн зохицуулалтыг өргөжүүлэх шаардлагатайг харгалзан 25 дугаар зүйлд зааснаар хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлбэрээр бичигдсэн 5 бүлэг, 27 зүйлтэй байна.

Хуулийн төслийн бүтцийн дугаарлалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.7-д заасан хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн тус хуулийн төслийг дагалдан боловсруулагдсан

1. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
2. Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
3. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
4. Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
5. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт нэмэлт оруулах тухай;
6. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
7. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай;
8. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
9. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дахь хэсэгт заасан дугаарлалт болон хуулийн төслийн заалтын байршилд тавигдах шаардлагыг хангасан байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн зохицуулалтыг дахин нягтлах шаардлагатай байна.

Бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, төслийн бүтэц нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.3-т заасанд нийцсэн байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёоны найруулгыг ойлгомжтой томъёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах шаардлагатай байна.

Хуулийн төсөлд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ХЭҮК болон холбогдох яамд, төрийн бус

байгууллагууд зэрэг нийт 36 байгууллагаас¹⁰ ирүүлсэн саналд шүүлт хийж үзвэл төслийн бичвэрийн томъёоллын ойлгомжтой байдлыг сайжруулах талаар тодорхой саналуудыг ирүүлсэн байна.

Эдгээр саналыг харгалзан төслийн үг найруулга, бичвэрийн томъёоллыг ойлгомжтой болгоход анхаарах шаардлагатай байна.

Тухайлбал:

- ✓ Татвараас нуугдах зорилгоор Татварын тухай хуульд хориглохоор заасан татварын схем зохиохыг хориглосон заалт нь татварын хууль тогтоомжид заасан байх тул давхардлыг арилгах хуулийн хэрэглээг сайжруулах үүднээс нийцүүлэх;
- ✓ Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийг 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгтэй уялдуулах;
- ✓ Нэг үүсгэн байгуулагчтай сан нь гүйцэтгэх захиралтай байж болох эсэхийг тодорхой болгох;
- ✓ Нийтийн санг заавал удирдах зөвлөл болон хяналтын хороотой байх зохицуулалтыг тусгах байдлаар шаардлагыг нэмэгдүүлэх.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

○Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

○

д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй

¹⁰ 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн ХЗДХ-ийн сайдын 1/1167 дугаар албан бичгийн дагуу ирүүлсэн санал

		байна. Харин зарим нэг тодруулах, уялдааг хангах, сайжруулах шаардлагатай асуудлыг үнэлгээний Зөвлөмж хэсэгт тусгасан болно.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах 143 хуулийн төслийг боловсруулсан байна.

○Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлээс гадна 7 дугаар зүйлд нэр томьёог Тайлбар хэлбэрээр тусгасан байна. Мөн хуулийн төсөлд заасан “санхүүгийн зохицуулалттай суваг” гэсэн нэр томьёонд тайлбар хийж, тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатай гэжээ.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.

			Хуулийн төслийн 11 дүгээр зүйлийн 11.4, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн уялдааг хангах
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг эргэн нягтлах, тус хуулиар ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хүлээлгэсэн үүрэг, хориглосон заалтыг нарийвчлан хариуцлага, хяналтын зохицуулалттай уялдуулахад анхаарах.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна. <i>Жич: Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.</i>
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй. Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дахин нягтлах.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Тийм	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.

13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.1.10-т заасан байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй. Тус төслийн зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд байсан тодорхойгүй, мэдээлэл, санхүүжилтийн нууцлагдмал байдлыг өөрчлөн, сайжруулсан давуу талтай хэмээн дүгнэж байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулахаар тусгасан байна. <i>Жич:Нэмэлт оруулах зохицуулалтын талаар Зөвлөмж хэсгээс дэлгэрүүлж харна уу.</i>

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

Харин хуулийн төслийн зохицуулалтыг тодруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах, нэр томъёог ойлгомжтой болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан “Сангийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

Дүгнэлт:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна. Гэвч зохицуулалтыг илүү нарийвчлах, хэрэгжих боломжийг нь нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Харин хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан сангийн онцлог зохицуулалтыг нарийвчлан тусгахтай холбоотой зорилтыг хуулийн төсөлд тусгайлан зохицуулаагүй байна.

- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төсөлд сангийн эрх зүйн байдлыг нарийвчлан сангийн санхүүжилтийн төрлөөр нь ялгамжтай тусгасан бөгөөд сангийн дотоод засаглал, бүтэц зохион байгуулалтыг тусгасан байна.

Гэвч нэг үүсгэн байгуулагчтай санд гүйцэтгэх удирдлага байх эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн сангийн тайлагналттай холбоотой зохицуулалт нь Төрийн бус байгууллагын тухай хуулийн тайлагналтын зохицуулалттай адил хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна.

- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна. Гэвч хуулийн төслийн зарим нэр томъёог тайлбарлах шаардлагатай байна.

- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна. Харин тус хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим нэг нэмэлт зохицуулалтыг тусгах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Зөвлөмж

Хуулийн төсөлд дараах агуулгын чанартай зохицуулалт нэмэх, тодруулах шаардлагатай байна.

Үүнд:

1. Хуулийн төслийн 12 дугаар зүйлд сан нь зөвхөн нийтэд тустай үйл ажиллагааг гүйцэтгэсэн тохиолдолд үйл ажиллагааны тайлангаа холбогдох байгууллагад заавал хүргүүлэх бол бусад үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр тайлагнахаар заасан нь хяналтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болохыг анхаарах;

2. Сан нь төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд нэхэмжлэгчийн шаардлагаар Иргэний шүүх дампуурсанд тооцох, гэмт хэрэг үйлдсэний улмаас татан буулгах ял оногдуулах бол Эрүүгийн шүүхээс татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр заасан боловч бусад үндэслэл буюу хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр татан буулгах шийдвэрийг аль шүүх гаргах нь тодорхойгүй байх тул тодруулах;

3. Хуулийн төслийн 5.2.5 болон 11.1, 11.2-д “хууль буюу дүрэмдээ зааснаар бусад зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх” гэсэн нь төрийн бус байгууллагын аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжийг хязгаарласан шинжтэй байх тул “аж ахуйн үйл ажиллагааны орлогыг дүрэмд зааснаас бусад зорилгоор ашиглах” гэж өөрчлөх;

4. Хуулийн төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т санг татан буулгах үндэслэл болгон заасан үйлдлийг зөрчилд тооцон зөвхөн торгох шийтгэл оногдуулахаар заасан байгааг анхаарч санг татан буулгах үндэслэлийг тодорхой болгох; “24.2.иргэний хэргийн шүүх энэ хуулийн 24.1.2, 24.1.3-т заасан үндэслэлээр, эрүүгийн хэргийн шүүх 24.1.4-т заасан үндэслэлээр холбоог татан буулгана.” гэж төсөлд өөрчлөлт оруулах;

5. Хуулийн төсөлд хориглосон эх үүсвэрээс санхүүжилт авсан, тайлан, мэдээллээ цахим хуудсандаа байршуулаагүй зэрэг хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хэрхэн шийдвэрлэх, ямар арга хэмжээ авах нь тодорхойгүй байх тул холбогдох зохицуулалтыг нэмж тусгах, тухайлбал Зөрчлийн тухай хуульд торгох санкц оруулах хуулийн төслийг боловсруулах;

6. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ашгийн төлөө бус хуулийн этгээдэд өгсөн хандивыг орлогын албан татвар ногдох орлогоос хасах зохицуулалтыг тусгах;

7. Хуулийн төслийн зарим нэр томъёог жигдлэх, найруулгыг ойлгомжтой томъёолох, хуулийн зүйл, заалт хоорондын уялдааг хангах, эш татсан зохицуулалтын зөрчлийг арилгах, үг үсгийн алдааг анхаарах.

Тухайлбал,

- ✓ Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг 14 дүгээр зүйлтэй уялдуулах;
- ✓ Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтын нэр томьёо тодорхой болгох үүднээс нэр томьёоны тайлбар хийх;
- ✓ Төслийн 8 дугаар зүйлд заасан сангийн нэртэй холбоотой зохицуулалтыг Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх хүрээнд батладсан холбогдох журмын зохицуулалттай нийцүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Судалгаа, статистик мэдээлэл

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик бүртгэл. 2021 он.
2. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл. 2021 он. ХЗДХЯ
3. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2021 он. ХЗДХЯ
4. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2021 он. ХЗДХЯ
5. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2021 он. ХЗДХЯ
6. Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлага, Тандан судалгаа хийсэн үнэлгээ. 2018 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.
7. Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн танилцуулга. Нээлттэй төслийн хэлэлцүүлэгт ХЗДХ-ийн Дэд сайд Б.Энхбаярын танилцуулсан илтгэл. 2018.10.26
8. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага: Үндэсний болон зарим орны эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа: 2018 он. Нээлттэй нийгэм форум
9. “Ашгийн бус байгууллын талаархи Монгол Улсын эрх зүйн зохицуулалт”. Эрх зүйн дүн шинжилгээ. 2017 он. ШХА, ХЗДХЯ хамтарсан Иргэдийн оролцоо II төсөл.
10. Монгол Улсын ашгийн төлөө бус хуулийн этгээдийн терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тайлан. 2020 он.

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Төрийн бус байгууллагын тухай хууль;
4. Иргэний хууль;
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
6. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;

7. Эрүүгийн хууль;
8. Зөрчлийн тухай хууль;
9. Дампуурлын тухай хууль;
10. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол;
11. Монгол Улсын Их хурлын 2016 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол;
12. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.